



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 63

Монгол

Монгол Улсын төрийн дээд шагнал одон медалиар
шагнуулах хүмүүсийн тодорхойлолт
өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын
тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр
зарлигийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Улсад олон жил үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг
үнэлж, Монгол Улсын төрийн дээд шагнал одон медалиар шагнуулахаар
тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Монгол Улсын
Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

"ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-ГООР

- | | |
|-----------------------------|---|
| 1. Цэрэн-Очирын Эрдэнэцэцэг | Богд сумын Сум дундын эмнэлгийн
хүүхдийн эмч |
|-----------------------------|---|

"АЛТАН ГАДАС ОДОН"-ГООР

- | | |
|-------------------------|---|
| 2. Раднаагийн Төгсгэрэл | Жаргалант сумын Сум дундын эмнэлгийн
дотрын их эмч |
| 3. Батын Чулуун | Богд сумын Сум дундын эмнэлгийн
хүүхдийн сувилалч, вакцинактор |

"ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ИАР

- | | |
|----------------------------|--|
| 4. Батсүхийн Энхтуяа | Баянлиг сумын Эрүүл мэндийн төвийн
нийгмийн эрүүл мэндийн ажилтан |
| 5. Гончигдоржийн Чулуунхүү | Баянлиг сумын Эрүүл мэндийн төвийн
багийн бага эмч |
| 6. Соотонгийн Баярмаа | Баянлиг сумын Эрүүл мэндийн төвийн
бага эмч |
| 7. Гүрбазарын Дэнсмаа | Баянлиг сумын Эрүүл мэндийн төвийн
асрагч |
| 8. Дашдуламын Цогзолмаа | Богд сумын Сум дундын эмнэлгийн |

9. Лхагвын Батцэцэг

Баянхонгор сум "Энэрэл" эмнэлгийн

сувилагч
эрхлэгч

10. Жанцанхоролын Хансмаа

Баянхонгор сум "Гурван-Эрдэнэ" эмнэлгийн
лаборант

ДАРГА



Д.ШИРМЭН



БЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 65

Номлон

Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол улсны Засгийн газрын 1996 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан "Авто замын сан төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журем"-ын 3 дахь хэсгийн 8 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Замын сангийн хөрөнгөөр 2015 онд гүйцэтгэх ажлын жагсаалт батлах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралтын 6, 10, 12 дугаар зүйлд өөрчлөлт оруулан гүйцэтгэх ажлын жагсаалт хөрөнгийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Зардлыг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэгд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралтын 6, 10, 12 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн
65 дугаар тогтоолын хэвсрэлт



**ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТТЭХ АЖЛЫН
ЖАГСААЛТ, ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ**

6	Эрдэнэцогт сумын Ямаан ус орчимын хайрган замыг засварлах	10.000.000
10.1	5.6-р багийн төвийн гадна авто зогсоол	14.275.990
10.2	7.9-р багийн төвийн гадна авто зогсоол	23.025.800
10.3	Номгон сургууль	2.673.624
10.4	2-р халуун ус	5.734.082
10.6	Спорт хороо	5.705.135
10.7	АЗДТГазар	8.053.812
10.8	Татварын уулзвар	1.803.240
10.9	12-р байрны уулзвар	8.797.171
10.10	17-р байрны уулзвар	9.557.740
10.11	Номуундалай сургууль	1.578.910
10.12	19-р байрны урд тал	9.049.820
10.13	Номуундалай сургуулийн урд уулзвар	2.473.620
10.14	3-р цэцэрлэг, Эрдэнэмандал бага сургуулийн зогсоол	13.815.480
12	Нөөц	19.575.011

.....оОо.....



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРДЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 66

Номлон

Хөрөнгө худалдах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, ахлах журам"-ын холбогдох заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2010 онд ашиглалтад орсон УАЗ-22069 маркийн БНА 96-18 улсын дугаартай гургон автомашиныг 2 удаа дуудлагаар худалдахаар зар явуулсан боловч нэг ч оролцогч ирээгүй тул худалдах доод үнийг 20 хувиар бууруулан 3,6 сая төгрөгөөр шинэчлэн баталсугай.
2. Автомашинуудын дуудлага худалдааг 2015 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 10 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 204 тоот өрөөнд зохион явуулж, дуудлага худалдаанаас орох орлогыг төрийн сан банкинд дахь Орон нутгийн өмчийн албаны 030051009 тоот дансанд төвлөрүүлсүгэй.
3. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.
4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 48 дугаар тогтоолын Бууцагаан сумын Засаг даргын тамгын газрын БНА96-18 улсын дугаартай автомашиныг худалдах доод үнийг тогтоосон заалтыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Д.ШИРМЭН





БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУУЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 67

Номгон

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.7, 20.1.11 дэх заалтуудыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор "Нью Майнинг" ХХК-ний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Төмөрбаатар /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч, төсөв, санхүүгийн бодлогын хорооны дарга/

Гишүүд: Б.Амаржаргал /Аймгийн санхүү хяналт, дотоод аудитын албаны дарга/


Д.Болдбаатар /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга/

С.Баярмаа /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга/

Э.Энхбат /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга/

Д.Доржтотов /Аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч/

2. Хяналт шалгалтын ажлыг шуурхай зохион байгуулж, ажлын хэсгийн санал дүгнэлтийг боловсруулж 2015 оны 07 дугаар сард багтааж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг ажлын хэсэг /Б.Төмөрбаатар/-т даалгасугай.

ДАРГА  ШИРЭГЭН

D:2015 en/ITHT_tagtool

2/6



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 68

Нөмөр

Журем шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг чндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Аймгийн ИТХ-ын шаг-алын журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэ-базар/-д даалгасугай.
2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 1999 оны 61 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  ДШИРМЭН



115032

АЙМГИЙН ИТХ-ЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эх орныхоо бүтээн байгуулалт, Баянхонгор аймгийг хөгжүүлэх үйлсэд ажил хөдөлмөрөөрөө хувь нэмрээ оруулсан хүмүүсийг үнэлж, урамшуулж алдаршуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Аймгийн ИТХ-ын шагналын төрөл

- 2.1. Аймгийн "Хүндэт иргэн" цол тэмдэг, мөнгөн шагнал
- 2.2. Аймгийн ИТХ-ын "Хүндэт тэмдэг", мөнгөн шагнал
- 2.3. Аймгийн ИТХ-ын "Талархал", мөнгөн шагнал

Гурав. Шагнал олгох журам

3.1. Аймгийн ИТХ-ын шагналаар шагнуулах иргэний талаар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцэн холбогдох материал, Тэргүүлэгчдийн тогтоолын хамт аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

3.2. Шагналд тодорхойлж буй иргэний материал нь дараах бүрдэлтэй байна.

3.2.1. Шагнуулах тухай үндсэн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан сумын ИТХ-ын болон аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн аль нэгийг хавсаргасан байна.

3.2.2. Шагнуулах иргэний тодорхойлолт

3.2.3. Аймгийн шагналаар шагнуулахаар сум, байгууллагаас өргөн мэдүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- а. Нэр дэвшигчийн анкет (нэгдүгээр хавсралтаар)
- б. Ажил байдлын тодорхойлолт
- в. Хамт олны хурлаар хэлэлцсэн тухай албан тэмдэглэл
- г. Холбогдох хэлтэс, агентлагуудын болон сум, байгууллагын даргын гарын үсэг бүхий өргөн мэдүүлэх албан бичиг зэрэг болно.

3.3. Шагналд тодорхойлсон хүний материал нь бүх талаараа үнэн зөв, бодит байдалд тулгуурласан байна.

3.4. Аймгийн ИТХ-ын ажлын албаны шагнал, урамшууллын асуудал хариуцсан ажилтан материалын бүрдлийг нягтлан шалгаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулж танилцуулна.

3.5. Шагналыг нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, тухайн сум, байгууллагын тэлш ойг тохиолдуулан олгоно.

3.6. Дараах болзлыг хангасан иргэнийг аймгийн ИТХ-ын шагналаар шагнана.
Үүнд:

3.6.1. Аймгийн "Хүндэт иргэн" цол, тэмдэгийг аймаг /хот/, сумыг бүтээн байгуулах, хөгжүүлэх, иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхэд өөрийн тодорхой хувь нэмрийг оруулсан, нутгийн захиргааны байгууллагад хөдөлмөрийн өндөр амжилт үзүүлсэн болон аймаг, орон нутгийн нэрийг улс, тив, дэлхийд гаргасан, тэр нь улс орны хэмжээнд үнэлэгдэж, иргэдийн сэтгэл санаанд нийцэж, хоногшсон нэр хүндтэй Монгол Улсын болон гадаадын иргэнд аймгийн "Хүндэт иргэн" цол, шагнал олгоно. Аймгийн "Хүндэт иргэн" цолоор шагнагдсан хүнийг аймгийн Хүндэт дэвтэрт бичиж алдаршуулна.

3.6.2. Аймгийн ИТХ-ын "Хүндэт тэмдэг"-ээр бүх хэвшлийн байгууллагуудад 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс тухайн ажлын байранд 5-аас доошгүй жил ажиллаж амжилт гаргаж Баянхонгор аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэнийг шагнана.

3.6.3. Аймгийн ИТХ-ын "Талархал"-аар бүх хэвшлийн байгууллагад 10-аас доошгүй жил ажиллаж үүнээс тухайн ажлын байранд 3-аас доошгүй жил ажиллаж амжилт гарган Баянхонгор аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэнийг шагнана.

3.7. Онцгой даалгаврыг амжилттай биелүүлсэн, хөдөлмөрийн гоц амжилт гаргасан, улс, олон улс, дэлхийн түвшинд урлаг, спортын өндөр амжилт гаргасан, шинэчлэх ухааны нээлт хийсэн иргэнийг дээрх шалгуурыг харгалзахгүйгээр шагнаж болно.

3.8. Аймаг, сумын хөгжилд хувь нэмэр оруулж, нийгмийн хариуцлагаа биелүүлдэг, салбартаа тогтвортой амжилт гаргаж буй байгууллага, хамт олныг аймгийн ИТХ-ын шагналаар шагнаж болно.

3.9. Аймгийн ИТХ-ын "Хүндэт иргэн" цол тэмдгийг 300 000 төгрөг, "Хүндэт тэмдэг"-ийг 50 000 төгрөг, "Талархал"-ыг 15 000 төгрөгийн мөнгөн урамшуулал дагалдана.

3.10. Аймгийн ИТХ-ын шагналыг аймгийн ИТХ-ын дарга, аль нэг Тэргүүлэгч, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга гардуулна. Дарга, Тэргүүлэгч, нарийн бичгийн

дарга очиж гардуулах боломжгүй тохиолдолд аймгийн ИТХ-ын даргын зөвшөөрснөөр тухайн сумын ИТХ-ын дарга, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга гардуулж болно.

Дөрөв. Аймгийн ИТХ-аас олгох шагналын нийтлэг тодорхойлолт

4.1. Аймгийн "Хүндэт Иргэн" шагналын үнэмлэх, тэмдэг:

4.1.1. Аймгийн "Хүндэт Иргэн" үнэмлэх нь цэнхэр өнгийн хавтастай байх бөгөөд нүүрэн талд нь аймгийн сүлдийг дүрсэлж доод талд нь "Баянхонгор аймгийн Хүндэт иргэн" гэж бичсэн байна.

4.1.2. Доторхи хуудас нь түмэн наст хээ бүхий шаргал өнгийн дэвсгэртэй байх бөгөөд Баянхонгор аймгийн хүндэт иргэн, дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж аймгийн ИТХ-ын дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

4.1.3. Тэмдэг нь зүүлт бүхий 7.4 см-ийн радиустай дугуй дотор аймгийн сүлдтэй байх бөгөөд алтадмал метал дэвсгэр дээр аймгийн сүлдийг цутгасан, зүүлт хэсэг дээр "Баянхонгор аймгийн Хүндэт иргэн" нэрийг алтадмал өнгөөр товойлгож гаргасан байна.

4.2. Аймгийн ИТХ-ын "Хүндэт тэмдэг" шагналын үнэмлэх, тэмдэг

4.2.1. Аймгийн "Хүндэт тэмдэг" үнэмлэх нь тэмдгийн хайрцагны дотор таарсан хэмжээтэй, нүүрэн талд нь аймгийн сүлдийг дүрсэлж доод талд нь "Баянхонгор аймгийн Хүндэт тэмдэг" гэж бичсэн байна.

4.2.2. Доторхи хуудас нь түмэн наст хээ бүхий шаргал өнгийн дэвсгэртэй байх бөгөөд Баянхонгор аймгийн Хүндэт тэмдгээр шагнагдсан тухай дугаар шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж, аймгийн ИТХ-ын дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

4.2.3. Тэмдэг нь зүүлт бүхий 7.4 см-ийн радиустай дугуй дотор аймгийн сүлдтэй байх бөгөөд алтадмал метал дэвсгэр дээр цутгасан, "Баянхонгор аймгийн Хүндэт тэмдэг" нэрийг алтадмал өнгөөр товойлгож гаргасан байна.

4.3. Аймгийн ИТХ-ын "Талархал" шагналын хавтас

4.3.1. Аймгийн ИТХ-ын "Талархал" шагнал нь А-4 хэмжээний цагаан өнгийн хавтастай байх бөгөөд нүүрэн талд нь аймгийн сүлдийг дүрсэлж доод талд нь Баянхонгор аймгийн ИТХ-ын "Талархал" гэж бичсэн байна.

4.3.2. Доторхи хуудас нь түмэн насан хээ бүхий шаргал өнгийн дэвсгэртэй байх бөгөөд Баянхонгор аймгийн хүндэт өргөмжлөл, дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг уйгаржин Монгол бичиг болон кирилл үсгээр бичиж аймгийн ИТХ-ын дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

.....оОо.....



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 69

Номгон

Шанх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх звалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн хурлын шагнал, түүнийг олгох журам"-ыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй нэр бүхий 19 хүнийг аймгийн ИТХ-ын "Хүндэтгэлийн талархал"-аар шагнасугай.

Хоёр. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэтгэлийн талархал"-ын дагалдах мөнгөн шагнал 190000 /Нэг зуун ерэн мянган/ төгрөгийг аймгийн ИТХ-ын төсвөөс гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ШИРМЭН

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
"ХҮНДЭТГЭЛИЙН ТАЛАРХАЛ"-ААР ШАГНУУЛСАН
ХҮМҮҮСИЙН ЖАГСААЛТ

№	Овог, нэр	Байгууллага, албан тушаал	Дагалдах мөнгөн шагнал
1	А.Бодь-Өнөр	Заг сумын цэцэрлэг	10000
2	Л.Энхжаргал	Заг сумын цэцэрлэг	10000
3	С.Наран-Амгалан	Цагдаагийн газар	10000
4	Г.Алтанбагана	Цагдаагийн газар	10000
5	Б.Сэргэлэн	Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв	10000
6	Ж.Даваа	Усны аж ахуй	10000
7	С.Ёндонсамбуу	Усны аж ахуй	10000
8	Б.Эрдмаа	Баянлиг сумын иргэн	10000
9	Б.Бархассүрэн	Баянлиг сумын иргэн	10000
10	Н.Төгсбуян	Зэвсэгт хүчний 339-р анги	10000
11	Д.Цогтбаяр	Зэвсэгт хүчний 339-р анги	10000
12	С.Цэцгээ	Эрдэнэцогт сумын иргэн	10000
13	Ж.Жамбал	Эрдэнэцогт сумын иргэн	10000
14	Х.Түвшинболд	Эрдэнэцогт сумын иргэн	10000
15	А.Баатар	Шижир титэм ХХК	10000
16	Ж.Бадамраадан	"Аян замын өртөө" хоршооны дарга	10000
17	Д.Доржбат	Баянхонгор "Тээвэрчин" хоршооны жолооч	10000
18	Б.Ганбаатар	Баянхонгор "Тээвэрчин" хоршооны жолооч	10000
19	О.Дашхүү	Хот хоорондын тээвэр Жолооч	10000